

**ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГГИЖ БУЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ
ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ
(2023 он)**

2023.10.02

Есөнзүйл сум

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч буй шалтгаан
1	2	3	4	5	6
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ					
2013 он					
1.	1.	<p>2013.03.14 Дугаар 21 Аймгийн музей, сумдын орон нутаг судлах танхим, Шанхын баруун хүрээ хийдийн үзмэр, эд өлгийн зүйлсийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах тухай.</p> <p>2.Сумдын орон нутаг судлах танхимын тохижилт үзмэрийн дэглэл, хадгалалт хамгаалалтыг сайжруулан, дохиоллын систем нэвтрүүлэх, орон нутгийн соёлын өвийг сурталчлах төв болгон хөгжүүлэхэд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн, шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p>	“Орон нутаг хөгжүүлэх сан”-гийн хөрөнгөөр Орон нутаг судлах танхим”-ыг камержуулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулах шатанд явж байна. Соёлын төвийн зүгээс иргэдийн гар дээр байгаа эд зүйлийг бүртгэн авч музейн үзмэрээ нэмэгдүүлж байгаа. Үүнд Хайрханы 3-р багийн иргэн Батсайхан-шатар, 2-р багийн иргэн Усанхүү-хутга зэрэг зүйлсийг үзмэрт нэмэгдүүлсэн.	70%	
2015 он					
2.	2.	<p>2015.07.03 Дугаар 53 Хүүхэд хамгааллын бодлого батлах тухай. (2015-2024)</p> <p>3.“Хүүхэд хамгааллыг бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шат тус бүрээр гаргаж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, орон нутгийн</p>	Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд Өвөрхангай аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газраас олгож буй 435,000 төгрөгний санхүүжилт болон аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс олгох 300,000 төгрөгийг зарцуулах төлөвлөгөөг боловсруулах зохих дансанд төвлөрүүлэн зарцуулах ажиллаж байна. Мөн хүүхэд хамгааллын бодлогын	90%	

		төсөвт тусган батлуулж, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл тусламжаар хэрэгжих хөтөлбөр төсөлтэй уялдуулан шийдвэрлэж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага, иргэдэд сурталчлан таниулж, мөрдүүлж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	хэрэгжүүлэх үйл ажиллагааг Хамтарсан багийн гишүүд, Ерөнхий боловсролын байгууллага, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагатай хамтран зорилтод бүлгийн айл өрхүүд болон эцэг эхйн хараа хяналтаас хол буюу байранд сууж буй хүүхдүүд, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн судалгааг шинэчэн тулгарч буй асуудлуудыг дор бүр нь шийдвэрлэн хараа хяналтыг сайжруулан ажиллаж байна.		
2016 он					
3.	3.	2016.10.24 Дугаар 61 Журам батлах тухай (School police) 2.“School police” эргүүлийн ажиллах журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Я.Ганбат), журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар (Ч.Самбуу-Ёндон), Ерөнхий боловсролын сургуулиудад үүрэг болгосугай.	БСШУСС-ын 2018 оны А/398 дугаар тушаалын дагуу School police эцэг, эхийн эргүүлийг 2022-2023 оны хичээлийн жилд эцэг, эхийн эргүүлийн хуваарийг анги бүрээр гаргаж, school police-ийн үеэр ажиллах заавар, тэмдэглэл хөтлөх дэвтэр, хантааз, дохиур мод, шүгэл зэргийг эцэг, эхчүүдэд хүлээлгэн өгч ажиллаж байна. School police-оор ажиллаж байгаа эцэг, эхчүүд тэмдэглэл хөтлөх дэвтэрт өдөр тутмын үйл ажиллагааны талаар тогтмол бичиж дараагийн эцэг, эхэд хүлээлгэн өгч хэвшсэн. Өнөөдрийн байдлаар сургуулийн орчинд сурагч бэртэж гэмтсэн асуудал гараагүй байна. Анги удирдсан багш эцэг эхийн эргүүл хийх явцын тэмдэглэлтэй өдөр тутам танилцаж дараагийн жижүүрт хүлээлгэн өгч хэвшсэн бөгөөд өдрийн сурагчид хичээл эхлэхээс өмнө эрт ирж сургуулийн хашаанд биенээ өшгичих, хөөцөлдөж тоглох зэрэг унаж бэртэх эрсдэлтэй тоглоомуудаар тоглож байгаа талаар багш нарт мэдээлэл өгсний дагуу багш нар анхааруулга өгч ажилласан. Мөн бага болон ахлах сургуулиудын машины зогсоолуудыг будаж засварласан бөгөөд сурагчид эрсдэлд өртөж болзошгүй бага сургууль, дотуур байр, гал тогооны цэвэрлэх байгууламж барихаар нүх ухсан байсныг дээд байгууллагын зөвшөөрлөөр дотуур байр орчмын нүхнүүдийг буцаан шороогоор дарж булсан. Бага сургуулийн доод талын /хуучин заалны урд хэсэг/ зам эргэх хэсэгт тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.	100%	
2018 он					
4.	4.	2018.06.27 Дугаар 08/02 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг тогтоох тухай 2.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион	2023 оны төлөвлөгөө нь 9,500,000 төгрөг хуримтлуулах бөгөөд, нийт 2023 оны 10 сарын байдлаар нийт 250 авто машины Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татвар 14,366,965 төгрөг орсон байна.	90%	

		байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д үүрэг болгосугай.			
5.	5.	2018.06.27 Дугаар 08/03 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай 2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг тогтоосон хувиар ногдуулж аймгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д үүрэг болгосугай.	2023 оны төлөвлөгөө нь 2,582,300 төгрөг төвлөрүүлэхээс 2023 оны 10-р сарын байдлаар нийт 1,935,000 төгрөг төвлөрсөн байна. Нийт 7 ААН, 1 иргэн байна. Хаан банк-678,892, Эргэлтийн эмийн сан 147,503, Мөнх цагаан толгой 75,000, Гурван тулгат цагаан хайрхан 80,000, Өв оюу илч 12,000, Алтан жолоот хүлэг 230,000, Бүтэнзаяа 60,000 тус тус төвлөрүүлээд байна.	100%	
6.	6.	2018 Дугаар 36 Сум хөгжүүлэх сангийн журмын хэрэгжилтийн тухай Аймаг, сумын Засаг дарга нар болон аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газарт даалгасан.	ЖДҮ хариуцсан мэргэжилтэн Сумын хоршоо хөгжүүлэх сангаас зээл олголтын 2022 оны 12 дугаар сард нийт 8 иргэн, 4 аж ахуйн нэгжүүдэд нийт 170,300,000 төгрөгний зээлийг олгосон. 2023 оны 09 дүгээр сарын байдлаар зээл олгохоор мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулан ажиллаж байна.	100%	
7.	7.	2018.11.12 Дугаар 77 Аймгийн хөтөлбөр батлах тухай (Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр 2019-2024) 2.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д даалгасугай.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй санхүүгийн дэмжлэгт 2 эмэгтэй, малжуулах хөтөлбөрт 9 эмэгтэй хамрагдаж байнгын ажлын байртай болсноос гадна мод тарих болон сэг зэм устгах нийтийг хамарсан ажилд 18 эмэгтэй хамрагдаж түр ажлын байраар хангагдсан. Мөн аж ахуйн нэгж албан газарт 5 эмэгтэй ажилд зуучлагдан орон одоогоор ажиллаж байна. Мөн санхүүгийн дэмжлэгт хамрагдаж буй иргэд аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдсан байгаа.	90%	
2019 он					
8.	8.	2019.08.29 Дугаар 56 Хөтөлбөр батлах тухай. (Хүмүүнлэгийн дэд хөтөлбөр 2019-2024) 2. Хүмүүнлэгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүхий л талын туслалцаа дэмжлэг үзүүлэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, Улаан загалмайн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулахтай холбогдсон зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган ажиллахыг аймгийн	Сумын анхан шатны Улаан загалмайн хорооноос сумын гамшгаас хамгаалах штабтай хамтран гамшгийн үед ард иргэдийн амь насыг гамшгаас хамгаалах, ослоос урьдчилан сэргийлэх, аюулт үзэгдэл тохиолдсон үед нөхөн сэргээх ажлыг хурдан хугацаанд зохион байгуулах, гамшгийн үед иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгийн бэлэн байдлыг хангах, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, хариу арга хэмжээ авах талаар сургалтуудыг зохион байгуулж ажилласан.	90%	

		Засаг дарга (Г.Ганболд), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.			
2020 он					
9.	9.	<p style="text-align: center;">2020.01.31 Дугаар 12 Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай</p> <p>1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 11/01 дүгээр тогтоолоор батлагдсан "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор хог, хаягдал боловсруулах үйлдвэр барих асуудлыг судлан шийдвэрлэх, энэ чиглэлээрх санал, санаачлага, төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д үүрэг болгосугай.</p>	Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллага аж ахуйн нэгжүүд болон хүнсний дэлгүүрүүд, ард иргэдийн ундны ус хангагч худгууд, Засаг даргын Тамгын газрын зарын самбар, сумын цахим хаягаар, цагдаагийн хэсэг, гэх мэт газруудаар Өвөрхангай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас гаргасан "Уриалга", Засгын газрын 189 дүгээр тогтоол зэргээр боршур хийж иргэдэд сурталчлах мөн уриалгыг байршуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн зорилтод бүлгийн иргэд болон аж ахуйн нэгж лбан байгууллагуудын албан хаагчдад Засгын газрын 189 дүгээр тогтоол, Уриалга, хог хаягдлын тухай хууль, байгаль орчны тухай хууль, олон удаа хэрэглэгдэх цаасан болон даавуун уутыг хэрэглэж занших, түүнийг өөрсдийн нөөц боломжоор хийж хүнсний дэлгүүрүүдээр худалдан борлуулах талаар хамтран сургалт сурталчилгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	90%	
10.	10.	2.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.	Сумын хэмжээнд хогийг ангилан ялгах преслэгч машиныг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр авч тохижилт үйлчилгээний ажилтанд хүлээлгэн өгөн хог хаягдлыг ангилан ялгалтыг хийж хэвшээд байна. Эмнэлгийн хог хаягдлыг цуглуулах уут сав, аюулгүй хайрцагыг эмийн тендэрт захиалан хангалттай авч, хар уутанд ердийн, шар уутанд халдвартай хог хаягдлыг цуглуулж, аюулгүй хайрцаганд тариур, ампул зэргийг хийж нээсэн он сар өдрийг тодорхой бичиж, 3/2 хэмжээнд хүрмэгц шатааж устгаж байна. Жилд дунджаар аюулгүй хайрцаг 250 ширхэгийг хэрэглэж байна. ЭМТ-ээс гарч буй эмнэлгийн болон ердийн хог хаягдлыг ангилан ялгаж хэмжээг тодрхойлон, бүртгэл маягыг журмын дагуу хөтлөж, хүний эрүүл мэндэд хоргүйгээр устгаж байна.	90%	

	11.	<p>3.Ус хангамж, ариутгах татуургын эрүүл ахуйн бүс болон хамгаалалтын зурваст газар олгохгүй байх, инженерийн шугам, сүлжээний төлөвлөлтийг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах, шинээр байгуулагдаж байгаа хасагдаж байгаа инженерийн шугам, сүлжээ болон байгууламжийн эрүүл ахуйн бүс, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тухай бүр тогтоож кадастрын зураглалд оруулан мэдээллийн сан үүсгэх ажлуудыг зохион байгуулж ажиллахыг ашиглагч байгууллага болон аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.</p>	<p>Есөнзүйл сумын нийт 250 мянган га талбай бүхий нутаг дэвсгэрт 6 гол, 40 гаруй булаг, шинээр сүүлийн хоёр жилд гаргасан 5 худаг, цөөн тооны хөв, нуур, баянбүрд байдаг. Эдгээрээс 2023 оны 3 дугаар улирлын тус сумын төвийн баруун зүүн талаар өмнөөс хойд чигт урсдаг Марзад, Хавцгайн голын эрэг, сав дагуух газрыг иргэд, төрийн албан хаагчдын оролцоотойгоор хог малын сэг зэмийг 1 удаа цэвэрлэж гаргасан хогийг нэгдсэн хогийн цэгт асгаж голын усны цэвэр ариун чанараа хадгалах, байгалийн жамаар сэргээх, хамгаалах ажлуудыг хийж гүйцэтгэсэн ажиллалаа.</p>	70%	
11.	12.	<p>2020.03.10 Дугаар 19 Зарим арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 1. Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд хепатитийн В, С вирусийн илрүүлэг шинжилгээнд хамрагдах зорилтот насны эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөх боломжтой 9848 иргэнийг даатгалд хамруулах, даатгалаа төлөх боломжгүй 3165 иргэний илрүүлэг шинжилгээнд шаардагдах түргэвчилсэн оношлуурын зардлын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д даалгасугай.</p>	<p>Элэг бүтэн монгол арга хэмжээний төлөвлөгөөг ЭМС-ын 2022оны 12сарын 05ны өдрийн а/577тушаалын дагуу 2022-2025 оны төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.Уг тушаалын дагуу төлөвлөгөө гарган мөн шалгуур үзүүлэлтэд тохируулан ажиллана. Сумын нийт иргэдийн дундах гепатит В.С вирусын халдвартай иргэн болон хэвлийн эхо шинжилгээнд элэгний өөрчлөлттэй гарсан иргэдийн судалгаа мэдээллийг цаг тухай бүрт бүртгэн хүн амын дундах тархалтын судалгааг гаргах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн ажиллана. 2022 -2023 онуудад дээрх зорилтуудын дагуу төлөвлөгөөг гарган Есөнзүйл сумын зорилтот насны болон яаралтай шинжилгээ өгөх шаардлагатай 128 иргэнээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авахад 5 иргэн элэгний В вирустай, мөн жирэмсний хяналтанд орсон 26 эхээс түргэвчилсэн шинжилгээ авахад 1 жирэмсэн эх В вирустай гарсан, отроор бусад орон нутагт байгаа 26 иргэнээс шинжилгээ авахад В/С вирус оношлогдоогой ба түргэвчилсэн оношлуураар илэрсэн иргэдэд анхан шатны зөвлөгөө өгөн дараагийн шатлалд хэвлийн эхо болон биохими зэрэг шинжилгээнд илгээсэн болно. Багийн эмч болон их эмч нар ЭМД-ын программд В.С вирустай иргэдээ бүртгэлжүүлэн гүйцэтгэлийн санхүүжилтээс нэг иргэний санхүүжилтээ аван ажиллаж байна.</p>	90%	
2021 он					

12.	13.	<p>2021.05.06 Дугаар 04/02 Журам шинэчлэн батлах тухай (аймгийн худалдаа, үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам) 2.Журмын захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн нэгдсэн санд бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлэгдсэний дараа аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдүүлж, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасугай.</p>	<p>2023 оны 3 дугаар улирлын байдлаар согтууруулах ундааны зүйл худалдан борлуулах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрөл сунгуулсан 4 аж ахуйн нэгж байна. Зөвшөөрөл сунгуулахаар өргөдлөө өгсөн аж ахуйн нэгжүүдийн стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхийг судалж материалыг бүрдүүлэн сумын салбар зөвлөлийн хурлаар оруулан дүгнэлт, материалыг аймгийн хууль зүйн хэлтэст хүргүүлэн зөвшөөрлийг авч хэвшээд байна. Сумын хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг тусгай зөвшөөрөлтэй 6 цэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Засаг даргын Тамгын газар, хүнс хариуцсан улсын хяналтын байцаагч, цагдаа нар хамтран тогтмол хяналт шалгалт хийж байна.</p>	70%	
13.	14.	<p>2021.04.26 Дугаар 30 Хөтөлбөр батлах тухай (Амар тайван Өвөрхангай 2021-2024) 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, хөтөлбөрт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасугай.</p>	<p>Амартайван Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд "Аюулгүй иргэн- Архигүй Есөнзүйл" арга хэмжээг зохион байгуулж аяны хүрээнд сар бүрийн эхний өдөр, долоо хоног бүр архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуй нэгж байгууллагуудад хяналт тавьж, өдөр оройн эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаандаа тогтмол шалгаж архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх тал дээр хяналт тавьж ажиллаж байна. 21 нас хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байх тал дээр хяналт тавьж. Сумын гудамж, талбайд өдөр, шөнө тодорхой цагуудад олон нийтийн эргүүлийн хамт хяналт шалгалтыг хийж ажиллаж, нийтийн хэв журам зөрчих, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарах явдлаас урьдчилан сэргийлж ажиллаж байна.</p>	90%	
14.	15.	<p>2021.06.07 Дугаар 37 Хөтөлбөр батлах тухай (Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 2021-2024) 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж, хөтөлбөрт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болшгүй гэр бүл, эрсдэлт нөхцөлд буй хүүхдүүдийн судалгааг жил болгон сумын Цагдаагийн хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хамтарсан багийн гишүүдтэй хамтран шинэчлэн ажиллаж байна. Жил болгон мэргэжилтэний мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлж зохих байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж буй хор нөлөө осол гэмтэл, түүнээс үүсэх өвчлөлийн шалгааныг тодорхойлон иргэдэд энэ талаарх ойлголтыг сурталчилан ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан болон хамьарсан баг хамтран хүчирхийлэлд өртсөн байхж болшгүй хүүхдүүдийг хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгээр тодорхойлоход хагас жилийн</p>	90%	

			<p>байдлаар хүчирхийлэлд өртсөн шинэ тэмдэг илэрсэн хүүхэд урьдчилан сэргийлэх үзлэгээр гараагү байна. Цаашид 0-18 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг үргэлжлэн явагдах тул хамтран үзлэг оношлогоонд хяналт тавин ажиллаж байна. Сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн болон сумын төсөвт байгууллагуудын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн гишүүд буюу нийт 5 гишүүн өвөрхангай аймагт зохион байгуулагдсан “Эцэг эхийн зөвлөлийг чадавхжуулах сургалт зөвлөгөөн” -д 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр амжилттай хамрагдаад байна. Холбогдох дээд байгууллагаас зохион байгуулж буй чадавхжуулах суургалтад Засаг дарга болон холбогдох мэргэжилтэн албан хаагчид цаг хугацаанд нь тогтмол хамрагдаж байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг Ерөнхий боловсролын сурагчдын дунд Дотуур байр, ахлах анги, дунд анги хэмээн хэсэгчлэн 3 удаа Сумын цагдаагийн хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нартай хамтран зохион байгуулаад байна</p>		
15.	16.	<p>2021.07.08 Дугаар 05/05 Сум дундын отрын нөөц нутаг, түүний хилийн зааг тогтоох тухай 1.Сум дундын 626 312.6 га отрын нөөц нутгийг зохистой ашиглах, хамгаалах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p>	<p>Жил болгоны Багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэн иргэдийн саналд үндэслэн сумын газар зохион байгуулалт бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд тусгаж бэлчээрийг чөлөөлөх хамгаалах ажлыг хийж хэрэгжүүлж байна.</p>	70%	
2022 он					
16.	17.	<p>2022.01.28 Дугаар 08/04 “Сумдын газрын үнэлгээний бүсийн зураг, итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 2.Газрын төлбөрийн бүсчлэл, итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээг мөрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д үүрэг болгосугай.</p>	<p>Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 5 дугаар хуралдааны 01 тогтоолоор газрын төлбөрийн суурь үнэ итгэлцүүр төлбөрийн хэмжээг батлуулан мөрдлөг болгон ажиллаж байна. Уг тогтоолоор бэлчээрийг 265 төгрөг, хадланг 375 төгрөг, атаршсан газрыг 1491 төгрөг, Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газрыг 60 төгрөг, барилга байгууламжийг доорх газрыг 100 төгрөгөөр суурь үнийг тогтоон ажиллаад байна.</p>	90%	

17.	18.	<p>2022.09.23 Дугаар 13/03 “Хөтөлбөр батлах тухай” 1.Өвөрхангай аймгийн “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай. 2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр ханган, шаардагдах хөрөнгийг эрүүл мэндийн салбарын төсөвт жил бүр тусган ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p>	<p>Хөтөлбөрийн 4 зорилтын хүрээнд 11 ажил төлөвлөн үйл ажиллагааг зохион байгуулснаар 8 ажлыг бодитойгоор хийлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Эмчийн байрыг засварлаж, суманд нэн шаардлагатай эмч мэргэжилтэн ирж ажиллахад бэлэн болгосон. • Ажлын байранд тав тухтай, үйл ажиллагаагаа хэвийн чанартай явуулах зорилгоор эмч мэргэжилтний ажлын өрөөг аль болох тус тусад нь зохион байгуулж, зарим эмч мэргэжилтэнд компьютер, олон үйлдэлт хэвлэгч зэргийг олгосон. • Тахилгины 1-р багийн эмчийн байрыг засварлаж ажиллах нөхцлийг нь сайжруулсан. • Сумаас алслагдсан Тахилганы 1-р багийн эмч хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгож уг баг эмчгүй болсонд ЭМТ-ийн дарга хүний нөөцийн бодлого барьж тэтгэдвэрт гарсан эмчтэй гэрээ хийн үргэлжлүүлэн ажиллахаар болсон нь тухайн эмчийн орлогын их үүсвэр нэмэгдэж нийгмийн баталгаа бага ч гэсэн хангагдаж үргэлжлүүлэн ажиллах урам зориг нь нэмэгдсэн • Мэдлэг ур чадвартаа дайчлан гүйцэтгэлийн санхүүжилийг авч чадсан эмч мэргэжилтнүүдэд 1 удаа цалингийн 40% иар урамшуулсан. • ЭМТ-д сувилагч мэргэжилтэн дутагдалтай байгаа учраас нутгийн 6 хүнийг туслах сувилагчийн түргэвчилсэн сургалтанд суралцуулж 2 нь төгссөн. <p>Ес зүй хүн чанарыг эрхэмлэсэн үйлчлүүлэгчийг дээдэлсэн хамт болох зорилгоор сард 1 удаа эмч мэргэжилтний ёс зүй сэдвээр дотоод сургалт хийж 117/ давхардсан тоо/ хүнийг хамруулснаар ёс зүйтэй холбоотой гомдол гараагүй байна.</p>	100%	
18.	19.	<p>2022.12.02 Дугаар 15/05 “Зорилтот жил болгон зарлах тухай” 2.“Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” жилийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p>	<p>Есөнзүйл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн 13/07 дугаар тогтоолоор “Хүнсний хамгамжийг нэмэгдүүлэх”-2023 зорилтод жилийн төлөвлөгөөг 5 бүлэг 25 зүйл заалттайгаар баталгаажуулж биелэлтийг нь хангаж ажиллаж байна. Зорилтод жилийн хүрээнд Хүнс хөдөө аж ахуйн газарт шаардлагатай мэдээ тайланг цаг хугацаанд нь тайлагнан ажиллаж байна.</p>	90%	

	20.	3.“Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан орон нутгийн хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тайлагнан ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Зорилгод жилийн ажлын хүрээнд 5тн үрийн төмс худалдан авч сумын нийт өрхийн 80 хувьд тус бүрд 20кг үрийн төмс үнэгүй олгож, аж ахуйн нэгж албан байгууллагууд 2,5тн төмсийг тариалж нийт 17,5тн төмс хураан авсан. Мөн ХХААХҮЯамны дэмжлэгтэй 10 төрлийн хөнгөлттэй үрийг тариаланчиддад тарааж өрхийн хэрэгцээнд тариалсан. Нарийн ногоо тариаланчидад 2ширхэг зуны хүлэмж олгосон.	90%		
19.	21.	2022.12.02 Дугаар 15/06 “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 18.Аймгийн Засаг дарга А.Ишдоржид даалгах нь: 18.1.Батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу хэрэгжүүлсүгэй.	Сумын 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөө 443 107.1 мянган төгрөг батлагдсанаас 9 сарын 30 ны өдрийн байдлаар 309 205.9 мянган төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг сар, улирлаар хуваарийн дагуу жигд ханган биелүүлэн ажиллаж байна.	90%		
	22.	18.2.Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай хэрэгжүүлж, орлогыг бүрэн төвлөрүүлэн зарлага санхүүжилтыг гүйцэтгэж байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай.	Есөнзүйл сумын ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 14/03 дугаар тогтоолоор сумын төсвийн нэмэлтийг шинэчлэн батлан төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 2 262 567.7 мянган төгрөгөөр баталж төсвийн ерөнхийлөн захирагч тэдгээрийн харъяа байгууллагуудад төсөв зарцуулах эрхийг өөрчлөн баталсан. Мөн Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 789 646 .8 мянган төгрөгөөр баталж төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу төсвийн сар, улирлын хуваарийг өөрчлөн төсвийг зориулалтын дагуу үр ашигтай хэрэгжүүлэн, орлогын төлөвлөгөөг сар, улирлын дагуу жигд ханган биелүүлэн, зарлага санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%		
	23.	18.3.Төсвийн сахилга хариуцлагыг сайтар ханган ажиллаж, төсвийн гүйцэтгэлд төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэн, өгсөн дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласугай.	Төсвийн сахилга хариуцлагыг сайтар ханган ажиллаж, төсвийн гүйцэтгэлд 2023 оны байдлаар төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэн ямар нэгэн зөвлөмж дүгнэлтгүй биелэлтийг 100 хувиар жигд ханган биелүүлэн ажиллаж байна.	100%		
2023 он						
	20.	24.	2023.05.23 Дугаар 19/05 “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2.Төсвийг батлагдсан дунд багтаан зориулалтын дагуу үр ашигтай зарцуулахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.	Есөнзүйл сумын ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 14/03 дугаар тогтоолоор сумын төсвийн нэмэлтийг өөрчлөлтийг шинэчлэн баталж төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу төсвийн сар, улирлын хуваарийг өөрчлөн төсвийг зориулалтын дагуу үр ашигтай хэрэгжүүлэн, орлогын төлөвлөгөөг сар, улирлын дагуу жигд ханган биелүүлэн, зарлага санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%	

21.	25.	<p>2023.06.27 Дугаар 20/04 “Хөтөлбөр батлах тухай”</p> <p>1.Аймгийн нийт мал сүргийн бүтцийг сайжруулах, үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор “Үхэр сүрэг” хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар, хөтөлбөрийн санхүүжилтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай. 2.“Үхэр сүрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Үхэр сүрэг хөтөлбөрийн хүрээнд 2019-2022 оны мал тооллогоор үхрийн тоо толгой 20 хувиар өссөн үзүүлэлтэй байна. Сумын хэмжээнд сүүлийн 4 жил үхрийн тоо толгойгоор сум орон нутгаа манлайлдаг Хайрханы 3-р багийн малчин А.Анхбаяр нь 2022 оны жилийн эцсийн мал тооллогоор 200 үхэр тоолуулж аймгийн аварга үхэрчин цол тэмдэгээр шагнуулсан. Мөн Сумын хэмжээнд Шилмэл сүрэг хоршоо Хайрханы 3 дугаар багийн иргэн О.Ганбат нар нь Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Эрүүл мэндийн төв болон ард иргэдийг 100 хувь сүүгээр ханган ажиллаж байна. Мөн сумын хэрэгцээнээс илүү гарсан сүүгээ Өвөрхангай аймагт борлуулж байна.</p>	90%	
22.	26.	<p>2023.08.11 Дугаар 21/02 “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай”</p> <p>3.Төсөвт орсон өөрчлөлтийг төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p>	<p>Есөнзүйл сумын ИТХ-ын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 14/03 дугаар тогтоолоор сумын төсвийн нэмэлтийг өөрчлөлтийг шинэчлэн баталж төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу төсвийн сар, улирлын хуваарийг өөрчлөн төсвийг зориулалтын дагуу үр ашигтай хэрэгжүүлэн, орлогын төлөвлөгөөг сар, улирлын дагуу жигд ханган биелүүлэн, зарлага санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	100%	
Бүлгийн дундаж дүн			90%		
Аймгийн ИТХ-ын хуралдааны тэмдэглэлээс					
23.	27.	<p>2017.04.10. Дугаар 02 Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан арга хэмжээ авч ажиллах тухай</p> <p>-Сумдын ОНХС, сум хөгжүүлэх сангаас иргэд, аж ахуйн нэгжийн авсан хугацаа хэтэрсэн зээл, худалдан авах ажиллагааны хууль зөрчсөн байдал, зориулалт бусаар зарцуулсан зардлуудын талаар тодорхой ажлын чиглэл гаргаж, зээлийг эргэн төлүүлэх, буруутай хүмүүст арга хэмжээ тооцох, цагдаа, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллах.</p>	<p>Сумын хоршоо хөгжүүлэх сангаас нийт 33 иргэн зээлтэй байснаас 2023 оны 09 дүгээр сарын байдлаар 3 иргэн хугацаанаасаа өмнө зээлээ бүрэн хаасан байна. Гэрээний хугацаа дуусгавар болсон 3 зээлийг шүүхэд өгч албадан гүйцэтгүүлэх болсон.</p>	70%	

2021 он					
24.	28.	2021.01.14 Дугаар 02 Аймгийн орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим ажилд хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх ажлын санал авах, эрэмбэлэх ажил хуулийн дагуу явуулж, эрэмблэгдсэн ажлыг санхүүжүүлэхээр хуралд танилцуулах	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх ажлыг урьд оны эхний улиралд багтаан иргэдээс санал авч Багийн Иргэдийн Хурлаар эрэмбэлж Засаг даргын захирамжаар ажлын хэсэг гарган эрэмбэлж нэгтгэн дүн шинжилгээ хийж сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулж Орон нутгийн хөгжлийн санд тавигдах журмын дагуу санхүүжүүлж ирсэн	90%	
	29.	2. Зураг төсөв батлагдаагүй ажлын хөрөнгийг төсвийн төсөлд тусгахгүй байх	2023 онд зураг төсөв нь батлагдаагүй улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил үйлчилгээ байхгүй.	100%	
	30.	3. Орон нутагт явагдаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажилд тавих хяналтыг сайжруулж, төндөрийн бичиг баримтыг хууль журмын дагуу бүрдүүлэх	Орон нутагт явагдаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 01 сарын 09-ны өдөр гарган батлуулан Улсын төсвийн хөрөнгөөр 3 ажил үйлчилгээ, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 ажил, үйлчилгээ, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 19 ажил, үйлчилгээг хийж хэрэгжүүлэхээр батлуулан хэрэгжилтэд тавих хяналт сайжруулалтыг цаг тухай бүрт нь гүйцэтгэж, төндөрийн бичиг баримтыг хууль журмын дагуу бүрдүүлэн хэрэгжүүлж ажиллаж байна.	90%	
	31.	4. Сумдын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдийн чадавхжуулах	Есөнзүйл сумын засаг даргын захирамжаар үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. 2023 онд худалдан авах ажиллагааны 3 удаагийн төндөрийг 2023 оны 4,5 дугаар саруудад зарлан арга хэмжээг зохион байгуулсан. 2023 оны хувьд үнэлгээний хорооны гишүүдийг чадавхижуулах тэдгээрийг арга зүйн зөвлөгөө мэдээ, мэдээлэл солилцох зэрэг сургалт семинарт тухай бүрт нь дотооддоо зохион байгуулан гишүүдийг тогтмол хамруулан ажиллаж байна.	100%	
	32.	5. Уламжлалтын эмнэлгийн барилгын газрын асуудлыг шийдвэрлэхэд холбогдох газруудад үүрэг чиглэл өгч, барилгын зураг төсвийг экспертизээр батлуулах	Есөнзүйл сум нь сум дундын нэгдсэн эмнэлэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг энэ оны хувьд уламжлалт эмнэлгийн барилга баригдах мөн газар зохион байгуулалтаар шийдэгдэх ажил байхгүй байна.	100%	

	33.	6. Уламжлалтын эмнэлгийн барилга барих ажлын зарласан тендерийн үнийн санал, шалгарсан компанитай байгуулсан гэрээний үнийн дүн зөрүүтэй, түүнчлэн санхүүжилтийн эх үүсвэр нь ойлголтын зөрүүтэй байгааг судалж танилцуулах	Есөнзүйл сум нь сум дундын нэгдсэн эмнэлэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг энэ оны хувьд уламжлалт эмнэлгийн барилга баригдах мөн газар зохион байгуулалтаар шийдэгдэх ажил байхгүй байна	100%	
	34.	7. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгөх	Сумын хэмжээнд ЗДТГ, ИХТ, ЕБС, СӨББ, Соёлын төв, Хүн эмнэлэг зэрэг засаг захиргааны төсвийн байгууллагуудын хувьд хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалгүй ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн болон 2023 оны хагас жилийн төрийн аудит болон дотоод хяналт шалгалтаар авсан зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилтийн биелэлтийг цаг тухай бүрт нь гарган биелэлтийг бүрэн ханган ажиллаж байна.	100%	
	35.	8. Энэхүү тэмдэглэлээр өгсөн үүргийн 5-7 дахь заалтын хэрэгжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 4 дүгээр сарын хуралдаанд, 1-4 дэх заалтын хэрэгжилтийг 11 дүгээр сарын хуралдаанд тус тус танилцуулах	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 11 дүгээр сарын хуралдаанд Есөнзүйл сумаас оруулах санал хүсэлт байхгүй. Аймгийн болон холбогдох дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг тухай бүрт нь гарган мэдээллэн ажиллаж байна.	100%	
25.	36.	2021.03.09 Дугаар 04 Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж буй талаар 1. Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санг төлөвлөх, үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллах, энэхүү үүргийн хэрэгжилтийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн 9 дүгээр сарын хуралдаанд танилцуулахыг Засаг дарга /А.Ишдорж/-д үүрэг болгосон.	Сумын хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 19 үйл ажиллагааны биелэлт хэрэгжилтийг тухай бүрт хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж гүйцэтгэл нь бэлэн болсон ажил, үйлчилгээг тухай бүрт хүлээн авч дээд шатны байгууллага, албан хаагчдад цаг тухай бүрт нь мэдээ, мэдээллээр бүрэн ханган ажиллаж байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажил, үйлчилгээ бүтээн байгуулалтын тайланг гарган ИТХ-ын Тэргүүлэгчдэд болон иргэдэд тайлан мэдээг тухай бүрт нь үнэн зөвөөр хүргэн ажиллаж байна.	100%	
2022 он					

26.	37.	<p>2022.05.10 Дугаар 03 1."Ахмадын талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 17 дугаар тогтоолыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, эрчимжүүлэх</p>	<p>Сумын Ахмадын хороо нь сумын Засаг дарга, аймгийн Ахмадын хороо Эрүүл мэндийн төвийн Ерөнхий эмчтэй нэг жилийн хугацаатай ажил төрлийн гэрээ байгуулан ажиллаж сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны төсөвт ахмад настануудад хууль тогтоомж, сумын Хөдөлмөр нийгмийн халамжийн мэргэжилтэнтэй хамтран сургалт зохион байгуулж Эрүүл мэндийн газартай гэрээ байгуулж ажилласны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй ахмад болон гэрээр хэвтэн эмчлүүлж байгаа ахмадуудад хүрч үйлчлэж байна. Бэлгийн тооллын Хаврын тэргүүн сарын шинийн нэгийг тохиолдуулан тухайн нийгэмд он удаан жил үр бүтээлтэй ажилласан өндөр настангууддаа сумын 90 жилийн ойн медаль, Ардын хувьсгалын 100 жилийн ойн медалуудыг 100 гаруй хүнд олгосны зэрэгцээ одоогоор авч чадаагүй дутуу хүмүүст олгох арга хэмжээг авч байна. Соёлын төвтэй хамтран ахмадуудын дунд нийтийн цэнгээнт бүжиг мөн Олон улсын эмэгтэйчүүдийн баяраар 30 гаруй ахмадуудыг хамруулан хүлээн авалтыг зохион байгуулж 5 төрлийн тэмцээнийг зохион байгуулж 400,000 төгрөгний шагнал олголоо. Аймгийн хэмжээний баруун бүс, хангайн бүс, зүүн бүс, төвийн бүс гэсэн спортын наадамд зүүн бүсдээ оролцон манай 50-аас дээш насны 16 ахмадууд 5 төрөлт тэмцээнд оролцон 22 батламж авч тэргүүн байр эзэлж аймагт 9 сард болох нэгдсэн Спортын бага наадамд багаараа оролцох амжилтыг гаргалаа. Ахмадын байрандаа УИХын гишүүдийн хандиваар ширээ сандал бусад тоног төхөөрөмжийг суурилуулан тогтмол үйл ажиллагааг явуулж байна. Ахмадууд маань ахмадын байрандаа ширээний теннис, шатар, даам, дартс, гранд голф, бие бялдаржуулах тоног төхөөрөмжөөр тогтмол хичээллэдэг болоод байна. Тарагт сумын Өгөөмөр амралтын газар настангуудаа амрах төлөвлөгөө гарган ажиллаж байна</p>	100%	
-----	-----	--	---	------	--



Бүлгийн дундаж дүн			95,4%	
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ				
27.	38.	Цахим-Архив хөтөлбөр 2019.06.07 №А/400	<p>Архив ОРG-AMS программ дээр захирамжлалын баримт бичиг, явуулсан бичиг өргөдөл гомдолыг тус бүрээр шивэж оруулан архив, бичиг хэргийн эрхлэгчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд архивын баримтыг цахим хэлбэрт оруулах заалтыг зааж биелэлтийг ханган ажиллаж байна. Байгууллагын бичиг хэргийн ажилтаны албан тушаалын тодорхойлолтод албан хэрэг хөтлөлтийн талаар болон архивын бичиг баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх талаар хүлээх эрх үүргийг тусгаж гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан биелэлтийг ханган ажиллаж байна. 2023 оны 9 сарын байдлаар цахимд Засаг даргын захирамж 127, Засаг даргын Тамгын газрын тушаал 12, өргөдөл гомдол 47, ирсэн бичиг 170-ийг тус тус шивж оруулаад байна. Архивын тусгай өрөөтэй 2 тавиуртай бөгөөд техник хэрэгсэл ном гарын авлагаар хангагдсан. Байгууллагын архивт ажилтнуудаас баримт бичгийг хуваарийн дагуу хүлээн авч архивын нөхөн бүрдүүлэлтийг жил бүр хийж ажиллаж байна. Суманд тэмдэглэж буй түүхэн ой онцлог үйл явдлын холбогдолтой баримт бичиг болон дүрс бичлэгийг CD дээр буулган файл болон цаасан хэлбэрээр архивт хадгалж байна.</p>	100%
28.	39.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай 2021.11.12 №А/561	<p>2022-2023 оны хичээлийн жилд мэргэжлийн багш, ажилчид хуваарьт болон хуваарьт бус сургалтуудад хамрагдаж мэргэжил боловсролоо дээшлүүлэхийн сацуу ажлын байран дээрээ тогтмол өөрсдийгөө хөгжүүлж ажиллалаа. Тухайлбал: "Төрийн албаны үнэт зүйл ба багшийн ёс зүй" сэдэвт сургалтад сургуулийн ёс зүйн зөвлөлийн гишүүд, аймгийн боловсрол, шинжлэх ухааны газраас зохион байгуулсан "Ээлжит хичээлийн цахим контентийг боловсруулах арга зүй" сэдэвт зөвлөх багш нарын сургалтад тус сургуулийн 4 багш, бага ангийн сурагчдын "Унших ба тоо бодох чадварыг хөгжүүлэх арга зүй"-г хэрэгжүүлэх, "Хичээл сургалтын үр дүнг үнэлэх үнэлгээний шалгуур"- ыг сургалтын үйл ажиллагаанд хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах зорилгоор Соёмбо бүсийн бага ангийн багш нарын дунд зохион байгуулсан ба тус сургалтад бага ангийн 9 багш, ээлжит хичээлийн цахим контент боловсруулах сургалтанд тус сургуулийн 4 багш, аймгийн БШУГ-аас зохион байгуулсан математик сонгоны бодлого бодох арга зүй сургалтад 2 багш, "Хариултын хуудас унших сканнерыг</p>	100%

		<p>ажиллуулах арга зүй” сургалтад 1 багш, Дэлхийн банкны санхүүжилттэй “Экспортыг дэмжих” төслийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) болон НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (UNIDO) хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад Итгэмжлэл, тохирлын үнэлгээний чадавхийг сайжруулах” техник туслалцааны дагуу хүнсний аюулгүй байдлын чиглэлээр дадлагажигчдад зориулсан цахим сургалтуудад тогооч нар, “Орон нутгийн БШУГ-ын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, ЕБС-ийн үнэлгээ хариуцсан сургалтын менежерүүдийг чадавхжуулах нь” сургалтад сургалтын менежер нар тус тус хамрагдаж мэргэжил боловсролоо дээшлүүллээ. Багш, удирдах ажилтнуудын мэргэжил боловсролыг дээшлүүлэх модуль сургалтуудад тус сургуулийн багш нар нийт 90 модуль сургалтад амжилттай бүртгүүлж 11 сарын эхний 7 хоногоос эхлэн хуваарийн дагуу онлайн хэлбэрээр хамрагдан дасгал даалгаврыг цаг тухай бүр хийж гүйцэтгэж 1 сард шалгалтаа амжилттай өгч батламж хуудсаа авсан. Мөн нэр бүхий 14 багш, удирдах ажилтнууд Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын хараа - 2050” сургалтад хамрагдаж батламж авсан. Мөн мэргэжлийн багш нар нь судлагдахууны хүрээнд 7 мэргэжлийн хөгжлийн бүлэгт нийт 26 багш, суралцахуйн хүрээнд 5 мэргэжлийн хөгжлийн бүлэгт 29 багш, 2023 оны 08 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй “Монгол физикчдийн үндэсний сургалт-зөвлөгөөн”-д физикийн багш, 23-25-ны өдрүүдэд зохион байгуулагдаж буй “Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг дэмжих арга зүй” сургалтад захирал 08 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан сургалтад дотуур байрны багш, 2023 оны 10 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд сургалтын менежерүүдийг үнэлгээний онол, арга зүйн чиглэлээр чадавхжуулах сургалтад сургалтын менежер нар хамрагдаж ажлын байран дээрээ өөрсдийгөө хөгжүүлж ажилласан. Багш, ажилчдын өөрийгөө хөгжүүлэх сургалтын зардалд нийт 5900000 төгрөг, багш нарын хичээл практикийн зардалд нийт 9600000, багш нарын дата хэрэглээнд нийт 3300000, багш бүрийг компьютержуулах аяны хүрээнд нийт 27252500 төгрөг, багш, ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд нийт 2634000 төгрөгийг</p>		
--	--	--	--	--

			<p>тус тус зарцуулсан байна. Мөн 5 багш найман айлын орон сууцанд амьдарч байна.</p> <p>ЭМТ: ЭМГ-аас зохион байгуулсан 12 удаагийн цахим, 5 удаагийн танхимын сургалтанд нийт эмч мэргэжилтэн 100 хамрагдсан Мөн дотоод сургалтыг сард 2-3 удаа зохион байгуулж, 312 /давхардсан тоогоор/ хамруулсан. Нийт ажилчдын 12% эрэгтэй, 88% эмэгтэй ажилладаг. Байгууллагын ажиллсагсадыг эрт илэрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад зардлын хөнгөлөлт 750000 төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн. Мөн ажилчдын тав тухтай байдал, чирэгдэлгүй ажиллуулах зорилгоор өрөөг тасалгааг тусад нь шийдвэрлэж, олон үйлдэлт өнгөт хэвлэгч, нөтбүүк зэргээр хангасан. Нийт ажилчдын урамшуулалд /3281607/ төгрөг олгосон, Албан хаагчийн сургалт хөгжлийн үйл ажиллагаанд томилолтын зардал 2 сая хоолны зардалд 1924,3 олгон ажиллаж байна.</p>		
29.	40.	“Илүүдэл жингүй” эртэч Монгол аян зохион байгуулах тухай 2022.02.16 А/69	<p>Үйл ажиллагааны хүрээнд 2 зорилт 14 заалт бүхий төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтод жилийн нээлтийн үеэр Сүүний ач холбогдол, эрдэс бодис найрлагын талаар сумын үхрийн фермерийн аж ахуй эрхлэгч Очирсум зөвлөгөө мэдээлэл өгч 87хүнийг хамруулсан.ЭМТ-өөс өглөөний цайны ач тус, сэдвээр сургалт хийж, Сүү таргаа ууцгаая гэсэн уриалга гаргасан. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтод жил “Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны “Өдөр бүр сүү тараг ууцгаая”үйл ажиллагааны хүрээнд хамт олноороо өглөөний дасгал хийж, цайндаа сүү, тараг аарц ууж хэвшиж, үүнийг бусад байгууллагуудад сурталчилсан. Мөн ЕБС-ийн 181 сурагчдад Өглөөний цайны ашиг тус, хор холбогдол, Сүү сүүн бүтээгдэхүүний ач тусын талаар сургалт хийсэн. “Зөв хооллоё” 14 хоногийн аян зохион аюулгүй хүнсийг хэрхэн зөв бэлтгэж хэрэглэх талаар эмч мэргэжилтэнд зааж, дасгал хөдөлгөөнтэй хослуулан 18.00 цагаас хойш хоол идэхгүй байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ажилдчынхаа нөхцөл боломжийг түшиглэн ажлын байрандаа хооллосон нь үр дүнтэй болж, жингийн илүүдэлтэй хүмүүс 1-3 кг жин хассан.“Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны хүрээнд зохион байгуулагдаж буй “ахмадуудаа хайрлая хөдөлгөөн хийж, хөгжилтэй байцгаая ” үйл ажиллагааны хүрээнд: 7 хоног бүрийн Даваа, Лхавга, Баасан гаригуудын</p>	100%	

			өглөөний 07.00 цагт нийт ахмадуудын дунд “Миний өглөө” сэдэвт алхалт, дасгал хөдөлгөөн хийхээр төлөвлөж эхлүүсэн. ЭМТ нь аяны хүрээнд хамт олноороо ажлын байрны дасгалыг өглөө 08.00, өдөр 11.00 цагт хийж хэвшсэн. Зөв хооллолт, эрүүл аюулгүй хүнсийг бэлтгэж, хэрэглэх талаар хийх үйл ажиллагааны удирдамжийн дагуу доорхи ажлуудыг хийлээ. Төрийн болон төрийн бус албан хаагчид нийт иргэдэд Эрүүл зөв хооллолт, хүнсийг зөв бэлтгэн хэрэглэх талаар сургалт зохион байгуулж 126 хүнийг хамруулсан.		
30	41.	Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэжээг авах тухай 2023.04.17 №А/240	Тус суманд мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Чин дөрвөн мэнд” хувийн мал эмнэлгийн малын эмч В.Сугаррагчаа 2023 оны 05 сарын 15 өдрийн А/36 дугаар захирамжаар гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,2,3,4 -р багийн үхэр сүрэгт нийт 6900 толгой малд 6900 тун вакциныг 96,07хувь хийж гүйцэтгэсэн .	100%	
31	42.	Малын халдварт, шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай 2023.03.04 №А/95	Тус сумын мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх өвчний вакцинжуулалтын 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Чин дөрвөн мэнд” хувийн мал эмнэлгийн малын их эмч В.Сугаррагчаа 2023 оны 04 сарын 15 өдрийн А/36 дугаар захирамжаар мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд ДХХ-17800 бог, ДХХ Энтробактериоз -15000 бог, цусан халдварт 2000 бод, Дуут хавдар 400 бод малд тус тус урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,2,3,4 -р багийн төлөвлөсөн айл өрхийг бүрэн хамруулсан мөн шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу туулгалдт, боловсруулалтанд бод 13209, бог 109,235 нийт 122444 толгой малыг хамруулсан байна.	100%	
32	43.	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр оруулан хаалгах болон төлбөрөөс чөлөөлөр тухай 2023.05.31 №А/283	Тус сумаас цэргийн дүйцүүлэх албанд 2023 оны 3 дугаар улирлын байдлаар цэргийн дүйцүүлэх албыг хааж буй иргэн байхгүй байна. 2023 оны хагас жилийн байдлаар 20 иргэн мөнгөн төлбөрийн тооцоог хийн ажиллаж байна.	100%	
Бүлгийн дундаж дүн				100%	

ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ	95,1%	
-------------------	-------	--

ХЯНАСАН: СУМЫН ЗАСАГ ДАРГА  Т. БАТ-ӨЛЗИЙ
ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Т. МӨНХЗУЛ

